



хоног тутмын хэвлэл
№ 12 дугаар сарын 04
№45 /618/

Монгол Улсын хууль

952

Монгол Улсын
Газрын тосны
тагтоол

980

Монгол Улсын Дээд
Хурлын тагтоол

998

Монгол Улсын
2009 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Хүний хөгжил сангийн тухай

**Газрын тосны бүтээгдэхүүний
онцгой албан татварын тухай**

**Хохирогчид нөхөх олговор
олгох тухай хуулийн зарим
зүйл, заалтыг шүүхийн практикт
хэрэглэх тухай**

Улсын Их Хурлын Тамгын Газар

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- | | | |
|------|---|-----|
| 582. | Хүний хөгжил сангийн тухай | 952 |
| 583. | Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай | 960 |
| 584. | Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай | 961 |
| 585. | Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай | 961 |

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|-------------------------------------|-----------|-----|
| 586. | Хууль, тогтоолын төсөл буцаах тухай | Дугаар 75 | 962 |
|------|-------------------------------------|-----------|-----|

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|------|---|------------|-----|
| 587. | Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай | Дугаар 137 | 962 |
| 588. | Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай | Дугаар 138 | 963 |
| 589. | Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай | Дугаар 139 | 963 |
| 590. | Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай | Дугаар 141 | 964 |

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|---|------------|-----|
| 591. | Ой тэмдэглэх тухай | Дугаар 269 | 964 |
| 592. | Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Дугаар 272 | 966 |
| 593. | Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай | Дугаар 279 | 967 |
| 594. | Хөтөлбөрт өөрчлөлт оруулах тухай | Дугаар 280 | 978 |
| 595. | Газрын тосны бүтээгдэхүүний онцгой албан татварын тухай | Дугаар 281 | 980 |
| 596. | Гэрээ шууд байгуулан хэрэгжүүлэх эрчим хүчний төслийн жагсаалт батлах тухай | Дугаар 283 | 981 |



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

597. Цөмийн энергийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Дугаар 05 985

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

598. Хохирогчид нөхөх олговор олгох тухай хуулийн зарим зүйл, заалтыг шүүхийн практикт хэрэглэх тухай Дугаар 31 998

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 11 дүгээр
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь ашигт малтмал, уул уурхайн салбарын орлогоос хуримтлал үүсгэж, тогтвортой өсөн нэмэгдэх байнгын нөөц бүрдүүлэн иргэддээ тэгш хүртээх зорилгоор хүний хөгжил сан байгуулах, түүнийг бүрдүүлэх, сангийн хөрөнгийг удирдах, зарцуулах, гүйцэтгэлийг нь тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хүний хөгжил сангийн тухай хууль тогтоомж

2.1. Хүний хөгжил сангийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль¹, Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай², Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай³, Засгийн газрын тусгай сангийн тухай⁴,

¹ Монгол Улсын Үндсэн хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

² Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 44 дугаарт нийтлэгдсэн.

³ Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

⁴ Засгийн газрын тусгай сангийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2006 оны 27 дугаарт нийтлэгдсэн.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай⁵, Компанийн тухай⁶, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль⁷ энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХҮНИЙ ХӨГЖИЛ САН, ТҮҮНИЙГ БҮРДҮҮЛЭХ, АРВИЖУУЛАХ

3 дугаар зүйл. Хүний хөгжил сан, түүнийг бүрдүүлэх эх үүсвэр

3.1.Энэ хуулийн 3.2-т заасан эх үүсвэрээс бүрдсэн хөрөнгийг Хүний хөгжил сан /цаашид "сан" гэх/ гэнэ.

3.2.Сангийн орлого нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ:

3.2.1.стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, хувьцаа борлуулсны орлого;

3.2.2.ашигт малтмалын орд газарт ашигт малтмал олборлох, боловсруулах үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээдийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн улсын төсөвт ногдох хэсэг;

3.2.3.энэ хуулийн 5.1-д заасан хөрөнгө оруулалтаас орох цэвэр ашиг;

3.2.4.стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглахтай холбогдуулан авсан урьдчилгаа мөнгө, зээл.

3.3.Сангийн хөрөнгийг Монголбанк дахь тусгай дансанд байршуулна.

4 дүгээр зүйл. Санд хөрөнгө төвлөрүүлэх

4.1.Энэ хуулийн 3.2.1, 3.2.2, 3.2.4-т заасны дагуу төсөвт төвлөрүүлсэн хөрөнгийг ажлын гурван өдөрт багтаан мөн хуулийн 3.3-т заасан сангийн дансанд шилжүүлнэ.

5 дугаар зүйл. Сангийн хөрөнгийг арвижуулах

5.1.Сангийн хөрөнгийг арвижуулах зорилгоор дотоодын болон

⁵ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1996 оны 11 дугаарт нийтлэгдсэн.

⁶ Компанийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 34 дугаарт нийтлэгдсэн.

⁷ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 48 дугаарт нийтлэгдсэн.

олон улсын санхүүгийн зах зээл дээр дараахь санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулна:

5.1.1. үнэт цаас, өрийн бичиг;

5.1.2. хадгаламж.

6 дугаар зүйл. Сангийн хөрөнгө оруулалтын жишиг багц

6.1. Энэ хуулийн 5.1-д заасан санхүүгийн хэрэгсэлд оруулах хөрөнгө оруулалтын тухайн жилийн жишиг багцыг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын өргөн мэдүүлснээр Засгийн газар санхүүгийн хэрэгсэл, бүс нутаг, валютын төрөл тус бүрээр тогтооно.

7 дугаар зүйл. Эрсдэлийн нөөц

7.1. Сангийн хөрөнгийн тодорхой хэсгийг хөрөнгө оруулалтын эрсдэлээс сэргийлэх зорилгоор нөөцөлж болох бөгөөд уг эрсдэлийн нөөцийг Монголбанканд тусгай данс нээж байршуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

САНГИЙН ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

8 дугаар зүйл. Сангийн хөрөнгийн удирдлага

8.1. Сангийн хөрөнгийн ерөнхий удирдлагыг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

8.2. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн төрийн мэдлийн хувьцааг эзэмших эрхийг төрийн өмчит хуулийн этгээд хэрэгжүүлнэ.

8.3. Энэ хуулийн 8.2-т заасан хуулийн этгээдийн дүрмийг Компанийн тухай хуульд нийцүүлэн Засгийн газар батална.

8.4. Энэ хуулийн 15.1-д заасан иргэн компанийн давуу эрхийн хувьцаа эзэмшигч байх бөгөөд хувьцааны ногдол ашиг буюу хишиг, хувь хүртэнэ.

8.5. Компанийн давуу эрхийн хувьцааг үнэ төлбөргүйгээр энэ хуулийн 15.1-д заасан иргэнд эзэмшүүлэх бөгөөд хувьцааг худалдах, арилжих, бэлэглэх, барьцаалах, өв залгамжлуулахыг хориглоно.

9 дүгээр зүйл. Компанийн үйл ажиллагааны үндсэн зарчим

9.1. Энэ хуулийн 8.2-т заасан хуулийн этгээд үйл ажиллагаандаа бие даасан, олон нийтэд ил тод байх, байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, хувь хүн, улс төрийн намын эрх ашигт хөтлөгдөхгүй байх үндсэн

зарчмыг баримтална.

**10 дугаар зүйл. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн
бүрэлдэхүүн, түүнийг томилох**

10.1. Энэ хуулийн 8.2-т заасан хуулийн этгээд төлөөлөн удирдах зөвлөлтэй байна.

10.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байх бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус бүр 1 хүний, Засгийн газар 6 хүний нэрийг тус тус дэвшүүлж, тэдгээрийг Засгийн газар томилно.

10.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг гишүүдийн дотроос төлөөлөн удирдах зөвлөлийн санал болгосноор Засгийн газар томилно.

10.4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил байна.

10.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн эдийн засаг, банк, санхүү, эрх зүйн аль нэг чиглэлээр мэргэжил эзэмшсэн, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан, ял шийтгүүлж байгаагүй иргэн байна.

10.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд дараахь этгээдийг нэр дэвшүүлэхгүй:

10.6.1. төрийн улс төрийн албан хаагч;

10.6.2. улс төрийн намын удирдах албан тушаалтан;

10.6.3. Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор.

10.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүнд дараахь шаардлага тавина:

10.7.1. татварын болон бусад хугацаа хэтэрсэн аливаа өргүй;

10.7.2. ял шийтгүүлж байгаагүй;

10.7.3. Өс зүйн болон бизнесийн нэр хүнд нь компанийг удирдахад харшлахгүй байх.

10.8. Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хуралдааныг улиралд нэгээс доошгүй удаа хийнэ.

10.9. Компанийн гүйцэтгэх захирлыг төлөөлөн удирдах зөвлөлийн санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлнө.

**11 дүгээр зүйл. Хяналтын зөвлөл**

11.1.Компанийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавих чиг үүргийг хяналтын зөвлөл хэрэгжүүлнэ.

11.2.Хяналтын зөвлөл 5 гишүүнтэй байх бөгөөд хяналтын зөвлөлийн гишүүдэд Улсын Их Хурлын Эдийн засгийн, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны болон Хууль зүйн байнгын хороо тус бүр 1 хүний, Төсвийн байнгын хороо 2 хүний нэрийг дэвшүүлж, тэдгээрийг Улсын Их Хурал томилно.

11.3.Хяналтын зөвлөл үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана.

11.4.Хяналтын зөвлөлийн эрх, үүрэг, үйл ажиллагааны журмыг компанийн дүрмээр зохицуулна.

12 дугаар зүйл. Мэдээллийн нээлттэй байдал

12.1.Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, компанийн удирдлагатай холбоотой мэдээллийг өдөр тутмын хэвлэлээр хагас жил тутам нийтэд хүртээмжтэй хэлбэрээр мэдээлнэ.

13 дугаар зүйл. Компанийн хөрөнгийн удирдах эрхийг шилжүүлэх

13.1.Энэ хуулийн 8.2-т заасан хуулийн этгээдийн чиг үүргийг дараахь шаардлагыг хангасан олон улсын санхүүгийн байгууллагад сонгон шалгаруулалтын үндсэн дээр менежментийн гэрээгээр хэсэгчлэн шилжүүлж болно:

13.1.1.олон улсын санхүүгийн зах зээл дээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай;

13.1.2.зээлжих зэрэглэл тогтоодог нэр хүнд бүхий олон улсын байгууллагаас AAA-аас доошгүй үнэлгээг 5-аас доошгүй удаа авсан.

13.2.Энэ хуулийн 13.1-д заасан сонгон шалгаруулалтын журам болон менежментийн гэрээг Засгийн газар батална.

13.3.Сонгон шалгаруулалтыг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны хамтарсан үнэлгээний баг явуулна.

13.4.Менежментийн гэрээнд Засгийн газрын зөвшөөрснөөр Монгол

Улсыг төлөөлж санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гарын үсэг зурна.

14 дүгээр зүйл. Сангийн хөрөнгийн эрсдэлийн удирдлага

14.1. Сангийн хөрөнгийн эрсдэлийн удирдлагыг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тодорхойлж, хэрэгжүүлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ САНГААС ХИШИГ, ХУВЬ ХҮРТЭЭХ

15 дугаар зүйл. Сангаас хишиг, хувь хүртээх

15.1. Сангаас хүн ам, өрхийн бүртгэлд бүртгэгдсэн, иргэний харьяаллын зөрчилгүй Монгол Улсын иргэнд хишиг, хувь хүртээнэ.

15.2. Энэ хуулийн 15.1-д зааснаар сангаас хишиг, хувь хүртээх хөрөнгийн хэмжээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална.

15.3. Сангаас хөрөнгө зарцуулах журмыг Засгийн газар батална.

16 дугаар зүйл. Сангаас хишиг, хувь хүртэх эрх дуусгавар болох

16.1. Дараахь тохиолдолд сангаас хишиг, хувь хүртэх иргэний эрх дуусгавар болно:

16.1.1. иргэн нас барсан;

16.1.2. иргэн Монгол Улсын харьяатаас гарсан.

16.2. Монгол Улсын иргэн нас барсан тохиолдолд тухайн иргэнд хуваарилагдсан боловч аваагүй байсан хишиг, хувийг өв залгамжлагчид нь олгож болно.

17 дугаар зүйл. Хишиг, хувь хүртэх хэлбэр, зарчим

17.1. Монгол Улсын иргэн дараахь хэлбэрээс сонгон сангаас хишиг, хувь хүртэнэ:

17.1.1. тэтгэврийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөр;

17.1.2. орон сууц худалдаж авсны төлбөр;

17.1.3. бэлэн мөнгө;

17.1.4. эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний төлбөр.

17.2. Иргэн энэ хуулийн 17.1-д заасан хишиг, хувийг тухайн жилдээ багтаан авч чадаагүй бол түүний хишиг, хувь дараагийн жилүүдэд



хадгалагдан үлдэх бөгөөд хадгалагдсан хугацаанд хүү тооцохгүй.

17.3.Иргэнд сангаас хишиг, хувь хүртээхдээ хүртээмжтэй, тэгш, шударга, үр ашигтай, олон нийтэд ил тод байх зарчим баримтална.

17.4.Энэ хуулийн 17.1-д заасан хэлбэрийн дагуу хишиг, хувь хүртэх журмыг Засгийн газар батална.

ТАВДУГААР БҮЛЭГ САНГИЙН ТӨСВИЙН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ, ӨРГӨН МЭДҮҮЛЭХ, БАТЛАХ, ТАЙЛАГНАХ

18 дугаар зүйл. Сангийн төсвийн төслийг боловсруулах, өргөн мэдүүлэх

18.1.Засгийн газар энэ хуулийн 3.2, 15.2-т заасныг үндэслэн сангийн төсвийн төслийг боловсруулж тухайн жилийн улсын төсвийн төслийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

19 дүгээр зүйл. Сангийн төсвийн төслийг батлах

19.1.Улсын Их Хурал сангийн төсвийг дараахь үзүүлэлтээр батална:

19.1.1.санд төвлөрүүлэх орлогыг хуульд заасан эх үүсвэрийнх нь төрлөөр;

19.1.2.сангаас зарцуулах хөрөнгийн хэмжээг хуульд заасан зориулалтаар;

19.1.3.эрсдэлийн нөөц хөрөнгийн хэмжээгээр.

19.2.Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй хувийн саналаар Хүний хөгжил сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

20 дугаар зүйл. Сангийн үйл ажиллагааны тайлан, түүнийг Улсын Их Хуралд тайлагнах

20.1.Санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн дагуу улсын төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгаж, Улсын Их Хуралд тайлагнана.

20.2.Энэ хуулийн 20.1-д заасан тайланд дараахь зүйлийг заавал тусгана:

20.2.1.сангийн хөрөнгө оруулалтын жишиг багц, түүний хэрэгжилтийн тухай;

20.2.2.сангийн хөрөнгийг менежментийн гэрээний дагуу удирдаж байгаа олон улсын санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны талаархи дэлгэрэнгүй танилцуулга;

20.2.3.сангийн хөрөнгийн эрсдэлийн удирдлагын тухай;

20.2.4.сангийн санхүүгийн байдлын тухай;

20.2.5.сангийн хөрөнгийн зарцуулалтын тухай.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ САНГИЙН ХӨРӨНГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ

21 дүгээр зүйл. Аудит

21.1.Сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд Үндэсний аудитын газар жил бүр аудит хийж, дүгнэлт гаргана.

21.2.Үндэсний аудитын газар нь энэ хуулийн 21.1-д заасан дүгнэлтээ Улсын Их Хуралд танилцуулна.

22 дугаар зүйл. Хөндлөнгийн аудит

22.1.Засгийн газар сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд жилд нэгээс доошгүй удаа олон улсын нэр хүнд бүхий аудитын байгууллагаар аудит хийлгэж, дүгнэлтийг Улсын Их Хуралд танилцуулна.

22.2.Энэ хуулийн 22.1-д заасан аудитын үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

23 дугаар зүйл. Сангийн тайланг нийтэд мэдээлэх

23.1.Сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, энэ хуулийн 21, 22 дугаар зүйлд заасан аудитын тайланг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

24 дүгээр зүйл. Хориглох зүйл

24.1.Сангийн хөрөнгийг энэ хуулийн 5 дугаар зүйл, 15.1-д зааснаас өөр зориулалтаар удирдах, захиран зарцуулахыг хориглоно.

25 дугаар зүйл. Хүний хөгжил сангийн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

25.1.Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасныг зөрчсөн этгээдтэй байгуулсан менежментийн гэрээг цуцална.



25.2.Энэ хуулийг зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээсгүй бол учруулсан бодит хохирлыг нөхөн төлүүлж, дараахь захиргааны шийтгэл ногдуулна:

25.2.1.энэ хуулийн 4.1-д заасныг зөрчсөн бол 25000-50000 хүртэл төгрөгөөр торгох;

25.2.2.энэ хуулийн 23.1-д заасныг зөрчсөн бол 150000-250000 хүртэл төгрөгөөр торгох.

26 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

26.1.Энэ хуулийг 2009 оны 11 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 11 дүгээр
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь заалт нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.4.27 дахь заалт:

"5.4.27 Хүний хөгжил сан."

2/6 дугаар зүйлийн 6.2.7 дахь заалт:

"6.2.7.Хүний хөгжил сан."

2 дугаар зүйл. Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан," гэсний дараа "Хүний хөгжил сан," гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Хүний хөгжил сангийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 11 дүгээр
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 3.2.5 дахь заалт нэмсүгэй:

"3.2.5. Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.2-т заасан эх үүсвэрээс бүрдэж, мөн хуулийн 17.1-д заасны дагуу зарцуулагдах тухайн жилд Улсын Их Хурлаас баталсан төсвийг хүний хөгжил сангийн төсөв гэнэ."

2 дугаар зүйл. Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт "орон нутгийн төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн төсөв" гэсний дараа " Хүний хөгжил сангийн төсөв" гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Хүний хөгжил сангийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 11 дүгээр
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 18.1.5 дахь заалт нэмсүгэй:

"18.1.5. Хүний хөгжил сангийн тухай хуулийн 3.2.1-д заасан ногдол ашиг."

2 дугаар зүйл. Энэ хуулийг Хүний хөгжил сангийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2009 оны 11 дүгээр
сарын 18-ны өдөр

Дугаар 75

Улаанбаатар
хот

Хууль, тогтоолын төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Засгийн газраас 2008 оны 4 дүгээр сарын 04-ний өдөр өргөн мэдүүлсэн "Шинэчилсэн бүртгэлд хамрагдсан иргэдэд олгох мөнгөний хэмжээг тогтоох тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Улсын Их Хурлын нэр бүхий гишүүдээс 2009 оны 6 дугаар сарын 18-ны өдөр өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газарт эрх олгох тухай хуулийн төслүүдийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Д.ДЭМБЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 10 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 137

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, "Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 3, "Дипломат албаны тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Түвдэндоржийн Галбаатарыг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Балдоржийн Даваадоржийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 10 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 138

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, "Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 3, "Дипломат албаны тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монгол Улсаас Канад Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дүгэржавын Готовыг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Канад Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Түндэвдоржийн Залаа-Уулыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 10 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 139

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, "Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 3, "Дипломат албаны тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Чех Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Очирын Энхтөрийг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Чех Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Сүрэнгийн Цоггэрэлийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 10 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 141

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, "Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 3, "Дипломат албаны тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Болгар Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Бадамдоржийн Батхишигийг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Болгар Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Цэрэндоржийн Ганхуягийг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 9 дүгээр
сарын 2-ны өдөр

Дугаар 269

Улаанбаатар
хот

Ой тэмдэглэх тухай

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Шинжлэх ухааны академийн Түүхийн хүрээлэн, "Хотгойдын Чингүнжав сан"-гийн саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монголын үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэгч, Хотгойдын Шадар ван Чингүнжавын мэндэлсний 300 жилийн ойг 2010 онд тэмдэглэсүгэй.

2. Монголын үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэгч, Хотгойдын Шадар ван Чингүнжавын мэндэлсний 300 жилийн ойг тэмдэглэх ажлыг зохион байгуулах хороог хавсралт ёсоор баталсугай.

3. Ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд дэмжлэг үзүүлэн, 2010

оны төсвийн багцдаа 200.0 (хоёр зуун) сая төгрөгийг тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаярт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД

Ё.ОТГОНБАЯР

Засгийн газрын 2009 оны 269 дүгээр
тогтоолын хавсралт

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТӨЛӨӨ ТЭМЦЭГЧ,
ХОТГОЙДЫН ШАДАР ВАН ЧИНГҮНЖАВЫН МЭНДЭЛСНИЙ
300 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга -Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр

Орлогч дарга -Хөвсгөл аймгийн Засаг дарга Л.Цэрэнжав

Гишүүд:-Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын Байнгын хорооны дарга Ө.Энхтүвшин (зөвшилцсөнөөр);

-Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны Байнгын хорооны дарга Д.Оюунхорол (зөвшилцсөнөөр);

-Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Г.Мөнхбаяр;

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Мишигжав;

-Завхан аймгийн Засаг дарга Я.Санжмятав;

-Ховд аймгийн Засаг дарга Г.Нямдаваа;

-Шинжлэх ухааны академийн Түүхийн хүрээлэнгийн захирал Ч.Дашдаваа;

-“Хотгойдын Чингүнжав” сангийн гүйцэтгэх захирал Д.Хулганаа (тохиролцсоноор);

-Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга “Хотгойдын Чингүнжав” сангийн тэргүүлэгч Л.Мөнхбаатар;

-Архивын ерөнхий газрын дарга Д.Өлзийбаатар;

-“Монголын цахилгаан холбоо” ХК-ийн гүйцэтгэх захирал О.Батчулуун;

- Доктор, профессор Б.Даш-Ёндон;
- Доктор, профессор Ч.Дагвадорж;
- Доктор, профессор Т.Гун-Аажав;
- Доктор, профессор Н.Бэгз;
- Хотгойд судлаач С.Чулуун.

Нарийн бичгийн дарга -Нүүдлийн соёл иргэншлийг судлах Олон улсын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан Д.Гарам-Очир

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 9 дүгээр
сарын 9-ний өдөр

Дугаар 272

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. "Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийн бүрэлдэхүүний тухай" Засгийн газрын 2008 оны 10 дугаар сарын 3-ны өдрийн 6 дугаар тогтоолын хавсралтад дор дурдсан агуулга бүхий 30 дахь заалтыг нэмсүгэй.

"30. Эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн хамтын ажиллагааны Монгол-Лаосын Засгийн газар хоорондын хамтарсан Комиссын Монголын хэсэг

Дарга –Эрүүл мэндийн сайд".

2. Мөн хавсралтын 4 дэх заалтыг "Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны Монгол-Италийн Засгийн газар хоорондын холимог Комиссын Монголын хэсэг -Дарга –Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд", 16 дахь заалтыг "Эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-БНАСАУ-ын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэг –Дарга –Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд" гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД

С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 9 дүгээр
сарын 9-ний өдөр

Дугаар 279

Улаанбаатар
хот

Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх үндэсний хөтөлбөр"-ийг 1 дүгээр хавсралт, "Осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаад үүрэг болгосугай.

3. Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний тодорхой хэсгийг олон улсын байгууллага, хандивлагчийн зээл, тусламжид хамруулах, хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн дотоод эх үүсвэрийг жил бүр улсын болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авч байхыг Эрүүл мэндийн сайд С.Ламбаа, Сангийн сайд С.Баярцогт, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД

М.ЭНХБОЛД

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С.ЛАМБАА

Засгийн газрын 2009 оны 279 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

ОСОЛ ГЭМТЭЛ, ХҮЧИРХИЙЛЛЭЭС СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөр боловсруулах үндэслэл

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тайлан мэдээгээр осол гэмтэл, хүчирхийллийн улмаас жил бүр дэлхий даяар 5 сая гаруй хүн амь насаа алдаж, 600 сая хүн хөгжлийн бэрхшээлтэй болж байгаа бөгөөд 2020 онд осол гэмтлийн улмаас нас барах хүний тоо 8.4 саяд хүрэх магадлалтай



байна. Осол гэмтэл, хүчирхийлэл нь дэлхийн хүн амын нас баралтын шалтгааны 9 дүгээрт, 15-44 насны хүн амын нас баралтын шалтгааны 7 дугаарт бүртгэгдэж байна.

Монгол Улсын хүн амын эрүүл мэндийн статистик мэдээгээр осол гэмтлийн улмаас нас барах нь хүн амын нас баралтын шалтгааны 3 дугаарт, осол гэмтлийн өвчлөл нь хүн амын өвчлөлийн 5 дугаарт орж байна. 2002 онд осол гэмтлийн тохиолдол 10000 хүн тутамд 274.6 байсан бол 2008 онд 422.4, осол гэмтлийн улмаас нас барсан үзүүлэлт нь 7.7 байсан бол 2008 онд 9.3 болж тус тус өссөн байна.

Осол гэмтлийн тохиолдол 25-29 насны 10000 хүний дунд 556.9 байгаа нь хөдөлмөрийн насны залуучууд осол гэмтэлд өртөн, хөдөлмөрийн чадвараа алдаж, тахир дутуу болж, нас барж байгааг харуулж байна.

Осол гэмтлийн бүртгэгдсэн тохиолдлын 69.3 хувийг эрэгтэйчүүд, 30.6 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаагаас үзэхэд эрэгтэйчүүд осол гэмтэлд өртөх нь эмэгтэйчүүдээс 2.2 дахин их байна.

Эрүүл мэндийн статистик мэдээгээр 10000 хүн амд ногдох үзүүлэлтээр эрэгтэйчүүд амиа хорлох тохиолдол эмэгтэйчүүдээс 7 дахин, бусдад хорлогдох тохиолдол 5 дахин, зам тээврийн осолд өртөх тохиолдол 5 дахин их байна.

Гэмтэл, согог судлалын үндэсний төв (цаашид "ГССҮТ" гэх)-д 2003-2007 онд нас барсан 1652 тохиолдол бүртгэгдсэнээс 30.4 хувь нь зам тээврийн ослын, 19.6 хувь нь бусдад хорлогдсоны, 17.9 хувь нь бүх төрлийн уналтын улмаас нас барсан байна.

Улаанбаатар хот руу чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөн жилээс жилд нэмэгдсэнтэй холбогдон ажилгүйдэл, гэр бүлийн болон хүүхдийн хүчирхийлэл, осол гэмтэл өсөх хандлагатай байна.

Хүүхэд гэмт хэргийн улмаас амь насаа алдах, бэртэж гэмтэх явдал жилээс жилд өсөж байгааг судалгаа харуулж байна. 2003-2005 онд гэр бүл, сургууль, гудамж, талбайд хэн нэгэнд зодуулснаас бэртэж гэмтсэн 5129 хүүхэд ГССҮТ-өөс эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан байна. 2008 оны мэдээгээр ГССҮТ-өөр үйлчлүүлсэн 0-4 насны хүүхдүүдийн 81.9 хувь нь түлэгдсэн, 15.4 хувь нь унаж бэртсэн байсан бол 5-19 насны хүүхдүүдийн 83.3 хувь нь зам тээврийн осолд орсон, 11.1 хувь нь унаж бэртсэн байна.

Осол гэмтэл нь манай оронд жил тутам нэмэгдэж байгааг харгалзан Засгийн газрын 2002 оны 156 дугаар тогтоолоор "Осол гэмтлээс сэргийлэх үндэсний хөтөлбөр"-ийг баталж 2002-2008 онд хэрэгжүүлсэн боловч нэг талаас хүн амын шилжилт хөдөлгөөн эрс нэмэгдсэн, нөгөө талаас хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбар хоорондын хамтын ажиллагаа, зохицуулалт хангалтгүй, санхүүжилт хүндрэлтэй байсны улмаас хөтөлбөрийн үр дүн зорилтот түвшинд хүрээгүй.

Уг хөтөлбөрийн хэрэгжилтийг Засгийн газар хэлэлцээд дахин хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд энэхүү

"Осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх үндэсний хөтөлбөр" (цаашид "хөтөлбөр" гэнэ)-ийг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас осол гэмтэл, хүчирхийллийн асуудлаар салбар хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх, осол гэмтлээс сэргийлэх үр ашигтай цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар өгсөн зөвлөмжийг харгалзан боловсруулав.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь осол гэмтэл, хүчирхийлэлд хүргэж байгаа эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, түүнээс сэргийлэх, осол гэмтлийн үед үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан олон улсын жишигт ойртуулах замаар осол гэмтэл, хүчирхийллийн сөрөг үр дагаврыг багасгахад оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилт

3.1. Хөтөлбөрийн зорилгыг биелүүлэхийн тулд дараахь зорилт хэрэгжүүлнэ:

3.1.1. зам тээврийн осол гэмтлийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хөдөлгөөнд оролцогчдын мэдлэг, хандлагыг өөрчлөн зохистой зан үйлийг төлөвшүүлэх, энэ чиглэлээрх салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах замаар зам тээврийн осол гэмтлийг бууруулах;

3.1.2. хүүхдийн осол гэмтлийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, амьдрах, сурах, хөдөлмөрлөх аюулгүй орчин бүрдүүлэх, эрүүл аж төрөх ёс, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх замаар хүүхдийн осол гэмтлийг бууруулах;

3.1.3. хүчирхийлэлд хүргэж байгаа шалтгаан нөхцөлийн хяналт, таңдалт болон салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах замаар эрсдэлт хүчин зүйлийг бууруулах.

Дөрөв. Хөтөлбөр хэрэгжүүлэх зарчим, үйл ажиллагааны үндсэн чиглэл

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараахь зарчим баримтална:

4.1.1. осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх үйл ажиллагаанд иргэн, гэр бүл, хамт олон, төрийн болон төрийн бус байгууллага, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог хангаж, салбар хоорондын хамтын ажиллагаанд тулгуурлах;

4.1.2. осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх үйл ажиллагааг нийт хүн ам, эрсдэлт бүлэг болон гэмтсэн хувь хүнд чиглэсэн, баримт нотолгоонд түшиглэсэн байх;

4.1.3. осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх үйл ажиллагааг

эрүүл мэндийн болон осол гэмтэлтэй холбоотой бусад хөтөлбөрийн үйл ажиллагаатай уялдуулах.

4.2. Хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл

4.2.1. осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох талаар дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:

4.2.1.1. осол гэмтэл, хүчирхийллийн тандалтын нэгдсэн тогтолцоо бүрдүүлж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах тогтвортой механизм бий болгох;

4.2.1.2. осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх сургалт, судалгааны төвийг тандалт судалгааны чиглэлээр өргөжүүлэх замаар үндэсний тандалт, мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх;

4.2.1.3. осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх чиглэлээр нутгийн захиргааны байгууллага, төрийн бусад байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхой болгох.

4.2.2. хүн амын амьдрах, сурах, хөдөлмөрлөх аюулгүй орчин бүрдүүлэх талаар дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:

4.2.2.1. байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх өөрийн эзэмшил газартаа аюулгүй орчин бүрдүүлэх, осол гарсан тохиолдолд тухайн байгууллага, аж ахуйн нэгж, айл өрх хариуцлага хүлээх талаархи хууль тогтоомжид холбогдох нэмэлт оруулах;

4.2.2.2. замын аюулгүй байдлыг хангасан орчин бүрдүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн хамтын ажиллагааны сүлжээ байгуулах.

4.2.3. осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх талаархи хүн амын мэдлэгийг дээшлүүлэх, зохистой зан үйл төлөвшүүлэх чиглэлээр дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:

4.2.3.1. осол гэмтэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох, дадал хэвшүүлэх албан, албан бус болон зайны сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах;

4.2.3.2. ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрт осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх чиглэлээр нэмэлт оруулах, багш нарын заах арга зүйг сайжруулах, сургалтын материалаар хангах;

4.2.3.3. осол гэмтэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажилд хэвлэл, мэдээллийн байгууллагыг татан оролцуулах.

4.2.4. осол гэмтэл, хүчирхийлэлд өртөгсдөд үзүүлэх тусламж үйлчилгээг сайжруулах талаар дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:

4.2.4.1. осол гэмтэл, хүчирхийлэлд өртөгсдөд эмнэлгийн тусламж

үйлчилгээ үзүүлэх хүртэлх хугацаанд үзүүлэх анхны яаралтай тусламжийн сургалтын модуль боловсруулах, сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах;

4.2.4.2. осол гэмтэл, хүчирхийлэлд өртөгсдөд нийгэм, хамт олонд суурилсан нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх талаар холбогдох байгууллагын ажилтнуудын үр чадварыг дээшлүүлэх;

4.2.4.3. хүчирхийлэлд өртөгсдөд үзүүлэх эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, сэтгэл зүй, хууль зүйн туслалцааг боловсронгуй болгох;

4.2.4.4. хүчирхийлэлд өртөгсдөд тусламж үзүүлэх чиглэлээр эмнэлэгт түшиглэсэн "нэг цэгийн үйлчилгээ"-г аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт байгуулах ажлыг дэмжиж, түүний чанар, хүртээмжийг сайжруулах.

Тав. Хөтөлбөр хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх ажлыг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.

5.2. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулна.

5.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутгийн түвшинд удирдан зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тайлагнах ажлыг бүх шатны Засаг дарга, мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

5.4. Хөтөлбөрийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах үндэсний хөтөлбөр, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр, Хүүхдийн хөгжил, хамгаалал үндэсний хөтөлбөр, Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө болон осол гэмтлийн чиглэлээр хэрэгжиж байгаа бусад төсөл, хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлнэ.

5.5. Холбогдох төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлаг хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хариуцсан салбар, чиг үүргийнхээ дагуу нарийвчлан боловсруулан баталж хэрэгжүүлнэ.

5.6. Осол гэмтэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны ач холбогдлын талаар олон нийтэд оновчтой, хүртээмжтэй хэлбэрээр сурталчилж, нийгмийн сэтгэл зүйг бэлтгэхэд анхаарч ажиллана.



5.7. Хөтөлбөр хэрэгжүүлэх явцад тохиолдож болох эрсдэл, саад бэрхшээлийг урьдчилан судалж нарийвчлан тооцоолох, түүнээс сэргийлэх, арилгах, даван туулах арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлнэ.

Зургаа. Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа, үе шат

6.1. Хөтөлбөрийг хоёр үе шаттай хэрэгжүүлнэ:

6.1.1. нэгдүгээр үе шат /2010-2012 он/-д хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг биелүүлэх орчныг бүрдүүлж, хэрэгжүүлж эхлэн тодорхой үр дүнд хүрсэн байна;

6.1.2. хоёрдугаар үе шат /2013-2016 он/-д хөтөлбөрт заасан арга хэмжээг бүрэн хэрэгжүүлнэ.

Долоо. Хөтөлбөр хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр

7.1. Хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;
- Засгийн газрын зарим тусгай сан (Эрүүл мэндийг дэмжих сан, Хүүхдийн төлөө сан, Улсын авто замын сан гэх мэт)-гийн хөрөнгө;
- байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;
- олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж;
- бусад эх үүсвэр.

Найм. Хөтөлбөрийн үр дүн, шалгуур үзүүлэлт

8.1. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ:

- зам тээврийн болон хүүхдийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх орчин тодорхой хэмжээнд бүрдэнэ;
- осол гэмтэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх чиглэлээр салбар хоорондын хамтын ажиллагаа сайжирна;
- осол гэмтэл, хүчирхийллийн тандалт, мэдээллийн үндэсний тогтолцоо бэхжинэ;
- осол гэмтэл, хүчирхийлэлд өртөгсдөд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэж, хүний нөөцийн чадавхи сайжирна;
- осол гэмтэл, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа явуулдаг хамт олон, байгууллагын тоо нэмэгдэнэ.



8.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

Шалгуур үзүүлэлт	2008 оны суурь түвшин	2012 онд хүрэх түвшин	2016 онд хүрэх түвшин
Зам, тээврийн ослын улмаас нас барсан тохиолдол /100000 хүн тутам/	18.7	16.5	14.0
Хүүхдийн осол гэмтлийн тохиолдол /10000 хүүхэд тутам/	78.1	75.0	73.0
Түлэгдэлт /10000 хүн тутам/	22.7	21.5	19.5
Осол гэмтэл, хүчирхийлэлд өртөгсдөд анхны тусламж үзүүлэх талаар сургалтад хамрагдсан: -цагдаа -онцгой байдлын албаны ажилтан	Байхгүй	30% 60%	60% 100%
Согтолтын зэрэг хэмжигч багажийн хангалт /тоо/	9	25	50
Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчлийн тоо	Хоногт 40-45	Хоногт 20	Хоногт 5-аас ихгүй
Хүчирхийлэлд өртөгсдөд тусламж үзүүлэх, эмнэлэг түшиглэсэн "нэг цэгийн үйлчилгээ"-ний тоо	-	3	8
Гэмтэл, согог судлалын кабинеттэй аймгийн тоо	14	20	21
Гэмтэл, согогийн тусламж, үйлчилгээний ор гаргаагүй аймгийн тоо	11	5	-
Гэмтэл, согог судлалын эмчгүй аймгийн тоо	5	2	-

Засгийн газрын 2009 оны 279 дүгээр
тогтоолын 2 дугаар хавсралт

**ОСОЛ ГЭМТЭЛ, ХҮЧИРХИЙЛЛЭЭС СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Үйл ажиллагаа	Хариуцах байршлалаа	Хамтран ажиллах байгууллага	Хугацаа
Осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг эрүүл мэндийн байгууллагын зохион байгуулалтыг оновчтой болгох талаар				
1	Осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх чиглэлээр хэрэгжж байгаа хөтөлбөр, төслийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах салбар хоорондын уулзалтыг тогтмолжуулах	ЗТБХБЯ	БСШУЯ, ХЗДХЯ, СЯ, НХХЯ, МХЕГ, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, хандивлагч байгууллагууд	Улирал тутам
2	ГССУТ-ийн Осол гэмтлийн сургалт, судалгааны төвийг тандралт, судалгааны чиглэлээр өргөжүүлэх арга хэмжээ авах	ЭМЯ	ДЭМБ, бусад хандивлагч байгууллага	2010-2012
3	Орон нутагт гэмтэл, согогийн кабинетийг бэхжүүлэх, хүний нөөцөөр хангах	ЭМЯ	БСШУЯ, ЭМГ, аймаг, нийслэлийн ЭМГ	2010-2012
4	Хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд жил бүр ханалт-шиножилгээ, үнэлгээ хийх	ЭМЯ	МХЕГ, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2012-2016
5	Осол гэмтэл, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, түүнийг бууруулах арга хэмжээний эдийн засгийн болон эрүүл мэндийн үр ашгийн талаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийхэд дэмжлэг үзүүлэх	ЭМЯ, БСШУЯ	Хандивлагч байгууллагууд	2010-2016
6	Осол гэмтэлд хүргэж байгаа хүчин зүйлээс сэргийлэх, аюулгүй орчин бүрдүүлэх, осол гэмтэлд хүргэсэн тохиолдолд хүлээх хармуцлалын тогтолцоог боловсронгуй болгох	ЗТБХБЯ, ХЗДХЯ	ЭМЯ, СЯ, ТББ	2010-2012
Хүн амын амьдарч, сурч, хөдөлмөрлөх аюулгүй орчин бүрдүүлэх талаар				
7	Хот төлөвлөлтийг хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангасан байдалаар хийх	ЗТБХБЯ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2010-2016

8	Замын хөдөлгөөний зохицуулагч нарыг жолоочийн согтолтын зэргийг тогтоох багажаар ээлж дараатай хангах	ЗТБХБЯ, ХЗДХЯ	СЯ	2010-2012
9	Барилга байгууламж, орон сууцны хороолол орчмын замын аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах	ЗТБХБЯ	МХЕГ, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2010-2016
10	Зам засварын ажлын чанарыг дээшлүүлэх, нийслэлд шинээр зам тавих хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх	ЗТБХБЯ	Нийслэлийн Засаг дарга	2010-2016
11	Хүүхдийн хамгаалалтын бус, суудал хэрэглэх шаардлагыг холбогдох дүрэм, журамд оруулан мөрдүүлэх	ЗТБХБЯ	ХЗДХЯ	2010-2011
12	Явган зорчигчдод зориулсан нүхэн болон гүүрэн гарам, явган зорчигч болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тусгаарлах хайс, хашлага, чиглүүлэх байгууламж байгуулах	ЗТБХБЯ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2010-2016
13	Хөдөлгөөн зохицуулах замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио шинээр тавих, засвар үйлчилгээ хийх хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх	ЗТБХБЯ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2010-2016
14	Замын стандартыг олон улсын жишигт хүргэх талаар арга хэмжээ авах	ЗТБХБЯ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	2010-2016
15	Биеийн тамирын багш нарын сургалтын хөтөлбөрт биеийн тамирын тэмцээн, уралдаан, хичээлийн үед уналт бартлээс сэргийлэх сургалтыг тусгах	БСШУЯ, ЭМЯ	Улсын болон хувийн биеийн тамирын дээд сургууль	2010-2011
16	Өвөл, зуны спорт (цана, чарга, тэшүүр, хурдан моринь)-ын уралдаан, тэмцээний үеэр осол гэмтэл гаргахгүй байх аюулгүй орчин бүрдүүлэх	ЭМЯ	БТСГ, ТББ	2010-2012
17	Сургууль, цэцэрлэг, хүүхдийн байгууллагын орчинд осол гэмтэл гаргахгүй байх орчин бүрдүүлэх зорилгоор биеийн тамир болон тоглоомын талбайн стандартыг мөрдүүлэх	БСШУЯ, ЗТБХБЯ	ЭМЯ, Хүүхдийн төлөө газар, орон нутгийн захиргаа, ТББ	2010-2016



Хүн амын осол гэмтэл, хүчрийллээс сэргийлэх мэдээллийг дээшлүүлэх, зохиистой зан үйлийг төлөвшүүлэх талаар			
18	Зам, тээврийн осол гэмтлээс сэргийлэх зорилгоор хамгаалалтын бус, хүүхдийн хамгаалалтын суудлыг хэрэглэж хэвшүүлэх	ЗТБХБЯ	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар
19	Хүн амд зам, тээврийн ослоос сэргийлэх мэдээлэл, дадал олгох албан, албан бус болон зайны сургалтын хөтөлбөр, гарын авлага, арга-чиглэл, зөвлөмж, мэдээлэл, сургалт, сурталчилгааны материал боловсруулах	БСШУЯ, ЭМЯ	ЗТБХБЯ, ХЗДХЯ, ТББ, хандивлагч байгууллагууд
20	Автомашинаас ялгарч байгаа утаанд хүний бие махбодийн үйл ажиллагааг алдагдуулах, хорт хавдар үүсгэх үйлчилгээтэй олон төрлийн бодис агуулагдаагийг харгалзан хуучин автомашиныг татварын бодлогоор хязгаарлах (хорт бодисын зөвшилфөх хэмжээ хэтэрсэн тохиолдолд нөхөн төлбөр авдаг байх) арга хэмжээ авах	ЗТБХБЯ	ЭМЯ
21	Зам, тээврийн осол гэмтлийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, эрүү аюулгүй орчин бүрдүүлэх талаар олон нийтийн саначилгыг дэмжиж жижиг төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	ЗТБХБЯ, ЭМЯ	МХЕГ, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, сууц өмчлөгчдийн холбоо, аж ахуйн нэгж, байгууллага
22	"Замын осол гэмтлээс сэргийлүгээ" сэдэвт уралдаан, тэмцээн, үзэсгэлэн, үзүүлэх сургууль, өдөрлөг зохион байгуулах	ЭМЯ, ХЗДХЯ	МҮОНРТ, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар
23	Автомашингүй өдрийг тэмдэглэн хэвшүүлэх, олон нийтэд зориулсан мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг аймаг, нийслэлийн хэмжээнд өргөжүүлэх	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	ЭМЯ, ЗТБХБЯ, ХЗДХЯ
24	Хүүхдийг осол гэмтэлд хүргэж байгаа нөхцөл шалтгааныг судлах, судалгааны дүнд үндэслэн зорилготой бүлэгт чиглэсэн сургалт, сурталчилгаа хийх	ЭМЯ	БСШУЯ, ГССҮТ, ХЗДХЯ, ЭМГ, НЭМХ, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, хэвлэл, мэдээллийн байгууллагууд

25	Хүчирхийлэлээс сэргийлэх асуудлаар албан, албан бус сургалт болон зайн сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулах, сургалт зохион байгуулах	БСШУЯ	ХЗДХЯ, ЭМЯ, ТББ	2010-2016
26	Сөргөлдөөнийг зөв аргаар шийдвэрлэх үр чадвар эзэмшүүлэх, хүчирхийллийн хор урсгийг ганиулах сургалтыг хүүхэд, залуучуудын дунд тогтмолжуулах	БСШУЯ	ХЗДХЯ, ТББ	2010-2016
Осол гэмтэл, хүчирхийлэлд өртөгсдөд үзүүлэх тусламж, үйлчилгээг сайжруулах талаар				
27	Осол гэмтлийн оношилгоо, эмчилгээг олон улсын түвшинд хүргэх нөхцөлийг бүрдүүлэх	ЭМЯ	ГССУТ, хандивлагч байгууллагууд	2010-2016
28	Эмч, эмнэлгийн ажилтан, холбогдох байгууллагын мэргэжилтнийг осол гэмтлийн үед авах арга хэмжээ, тусламж үйлчилгээний гарын авлага, удирдамжаар хангах	ЭМЯ	ЗТБХБЯ, ХЗДХЯ, хандивлагч байгууллагууд	2010-2011
29	Хүчирхийлэлд өртөгсдөд тусламж, үйлчилгээ үзүүлэх талаар эрүүл мэндийн болон нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, хуульч, шүүгч, цагдаагийн ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх	ЭМЯ	ХЗДХЯ, НХХЯ, ТББ, Жендэрийн тэгш байдлын үндэсний хороо	2010-2012
30	Хүчирхийлэлд өртөгсдөд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний удирдамж, заавар, гарын авлага, үйлчилгээний стандарт боловсруулах	ЭМЯ	ЭМГ, ГССУТ, Жендэрийн тэгш байдлын үндэсний хороо	2010-2012
31	Хүчирхийлэлд өртөгсдөд тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлэг тушигласан "Нэг цагийн үйлчилгээ"-ний загварыг аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт байгуулах ажлыг дэмжих	ЭМЯ	ХЗДХЯ, НХХЯ, ТББ, хандивлагч байгууллагууд, Жендэрийн тэгш байдлын үндэсний хороо	2010-2012

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2009 оны 9 дүгээр
сарын 9-ний өдөр

Дугаар 280

Улаанбаатар
хот

**Хөтөлбөрт өөрчлөлт оруулах
тухай**

Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 10.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 2005 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 64 дүгээр тогтоолоор баталсан "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр"-ийн "4.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, үе шат" гэсэн хэсгийн 3 дугаар үе шат: 2009-2010 он

Энэ үе шатанд хэрэгжүүлэх арга хэмжээг тухайн үед нь баталж мөрдөнө." гэснийг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

"3 дугаар үе шат: 2009-2010 он

а) 1, 2 дугаар үе шатанд хэрэгжүүлэх арга хэмжээг дуусгах;

б) мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг бүсчлэн байгуулах;

в) тоног төхөөрөмжийг жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд санхүүгийн түрээс (лизинг)-ээр олгох үйлчилгээ хариуцсан нэгж байгуулж ажиллуулах;

г) жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн хөдөлмөр хамгаалал, сургалт, мэдээллийн үйлчилгээг гэрээний үндсэн дээр мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх;

д) жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах;

е) жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;

ж) жижиг, дунд үйлдвэрийг дэмжих талаар Засгийн газраас явуулж байгаа бодлого, үйл ажиллагааг сурталчлах;

з) албан бус хөдөлмөр эрхлэгчдийн дунд жижиг, дунд үйлдвэр (компани, хоршоо, нөхөрлөл) эрхлэх чиглэлээр төрөлжсөн сургалт зохион байгуулах."

2. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийг 2009-2010 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт жил бүр тусган, дотоод, гадаадын хөрөнгө

оруулагчдыг татан оролцуулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Сангийн сайд С.Баярцогт, Гадаад харилцааны сайд С.Батболд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД**

М.ЭНХБОЛД

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Т.БАДАМЖУНАЙ

Засгийн газрын 2009 оны 280 дугаар
тогтоолын хавсралт

**ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙГ
2009-2010 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Үйл ажиллагаа	Байгууллага	Хөрөнгийн урьдчилсан тооцоо (сая.төг)
1	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг бүсчлэн байгуулах	БСШУЯ НХХЯ ХХААХҮЯ	1000.0
2	Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд санхүүгийн түрээс (лизинг)-ээр тоног төхөөрөмж олгох үйлчилгээ	ХХААХҮЯ	2000.0
3	Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн хөдөлмөр хамгаалал, сургалт, мэдээллийн үйлчилгээг гэрээний үндсэндээр мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх	ХХААХҮЯ ТББ	50.0
4	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах	ХХААХҮЯ СЯ	79900.0
5	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах	ХХААХҮЯ СЯ ГХЯ	Гүйцэтгэл
6	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих талаар Засгийн газраас явуулж байгаа бодлого, үйл ажиллагааг сурталчлах	ХХААХҮЯ	33.8

7	Хөвсгөл, Ховд аймагт Технологи дамжуулах төв байгуулах	ХХААХҮЯ БСШУЯ НХХЯ	1800.0
8	Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн дунд жижиг, дунд үйлдвэр (компани, хоршоо, нөхөрлөл) эрхлэх чиглэлээр төрөлжсөн сургалт зохион байгуулах	ХХААХҮЯ Татварын ерөнхий газар	500.0
9	Бизнес инкубаторын үйл ажиллагааг санхүүжүүлэх, Архангай, Баянхонгор, Хэнтий, Ховд, Хөвсгөл, Дорнод аймагт Бизнес инкубатор шинээр байгуулах	ХХААХҮЯ	2056.0
10	Төрийн үйлчилгээний талаархи санал, хүсэлт, гомдлыг хүлээн авах "Шуурхай үйлчилгээний цэг" ажиллуулах	Бүх яамд	250.0
ДҮН			87590.0

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр

Дугаар 281

Улаанбаатар хот

Газрын тосны бүтээгдэхүүний онцгой албан татварын тухай

Онцгой албан татварын тухай хуулийн 6.7-г үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Импортоор оруулж байгаа автобензин, дизелийн түлшний онцгой албан татварын хэмжээг 2009 оны 9 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн дор дурдсанаар тогтоосугай:

№	Хилийн боомтын нэр	Ногдуулах онцгой албан татварын хэмжээ (төгрөгөөр)		
		Автобензин (шинжилгээний аргаар тодорхойлсон октаны хэмжээ)		Дизелийн түлш
		90 хүртэл	90 болон түүнээс дээш	
1	Цагааннуур, Ярант, Боршоо, Арцсуурь, Тэс, Бургастай, Гашуунсухайт, Шивээхүрэн, Баянхошуу, Бичигт, Хавирга	0.0	10.000	49.000

2	Ханх, Ульханмайхан	0.0	10.000	49.000
3	Сүхбаатар, Замын-Үүд, Эрэнцав, Алтанбулаг	0.0	40.000	65.000

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Газрын тосны бүтээгдэхүүний талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2009 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 203 дугаар тогтоол, "Газрын тосны бүтээгдэхүүний үнийн өсөлтийн эсрэг авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2009 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 255 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД**

М.ЭНХБОЛД

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 9 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 283

Улаанбаатар
хот

Гэрээ шууд байгуулан хэрэгжүүлэх эрчим хүчний төслийн жагсаалт батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1.6, 34.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2009 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ын XI.4, XI.5-д заасан нийслэлийн зарим өрхийг эрчим хүчинд холбож, цахилгааны асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний хүрээнд гэрээ шууд байгуулан гүйцэтгэгчийг нь сонгох төслийн жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2. Гэрээ шууд байгуулахдаа санхүү болон техникийн чадавхи сайтай, дадлага туршлагатай, найдвартай гүйцэтгэгчийг сонгож, хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Г.Мөнхбаярт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД**

М.ЭНХБОЛД

**ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ
ХҮЧНИЙ САЙД**

Д.ЗОРИГТ



**Засгийн газрын 2009 оны 283 дугаар
тогтоолын хавсралт**

**ГЭРЭЭ ШУУД БАЙГУУЛАН ГҮЙЦЭТГЭГЧИЙГ
СОНГОХ ТӨСЛИЙН ЖАГСААЛТ**

№	Төслийн нэр, байршил	Өрхийн тоо	Төсөвт өртөг (сая.төг)
Эрчим хүчинд холбогдоогүй өрхийг эрчим хүчинд холбох төсөл			
Баянзүрх дүүрэг			
1	ХП хороо, Чулуун-Овоотын төмөр замын хойд талд	219	116.600
2	ХХП хороо, зүүн Алтан-Өлгийн АТП-2183 дэд станцын зүүн талд	63	71.000
3	ХХП хороо, баруун Алтан-Өлгийн АТП-2154 дэд станцын ард	177	102.778
4	IX хороо, Шархадны эцсийн АТП-780 дэд станцын ард	87	62.000
Сүхбаатар дүүрэг			
5	ХҮШ хороо, Хадатын ам	150	82.000
6	ХҮШ хороо, Гүнжийн ам	252	145.000
Сонгинохайрхан дүүрэг			
7	I хороо, Толгойтын 110-127 дугаар гудамж	144	90.000
8	ХХIY хороо, Хустайн 1-5 дугаар гудамж, Толгойтын Баруунсалаа	99	77.000
9	ХХIY хороо, Зээлийн 1-5 дугаар гудамж, Толгойтын Баруунсалаа 1	60	73.500
10	ХХIY хороо, Зээлийн 1-5 дугаар гудамж, Толгойтын Баруунсалаа 2	69	58.000
11	ХХIY хороо, Зээлийн 17-23 дугаар гудамж, Толгойтын Баруунсалаа	96	77.000
12	ХХIY хороо, Хустайн 1-5 дугаар гудамж, Толгойтын Баруунсалаа 2	129	108.000
13	X хороо, Зүүнбаян цагааны 32-35, 16 дугаар гудамж	96	81.000
14	ХХП хороо, Тахилтын ам /Монголын ядуурлаас хамгаалах холбооны байр/	123	85.595
15	ХХIY хороо, Зээлийн 23-28 дугаар гудамж, Шороотын ам	138	108.000
16	ХХY хороо, Баянхошуу 35/6 яВ-ын дэд станцын өргөтгөл		150.000
17	ХХП хороо, Баруунтуруун тахилтын айл өрхийн цахилгаан хангамжийн нэмэлт хөрөнгө		79.000
18	ХХIY хороо, Шороотын амны шинэ суурьшлын бүс		72.800
19	Баянголын амны шинэ суурьшлын бүс		205.120
20	IX хороо, Цаг уурын станц	141	83.000

21	IX хороо, зүүн Ард Аюушийн 1 дүгээр гудамжны ХТП-880-ын зүүн талд Хан-Уул дүүрэг	96	36.000
22	XIY хороо, Өлзийт хороолол, Бурхантын 3 дугаар хэсэг	90	54.000
23	XIY хороо, Өлзийт хороолол, Бурхантын 1 дүгээр хэсэг	171	98.500
24	XIY хороо, Өлзийт хороолол, Бурхантын 5 дугаар хэсэг	39	51.000
Багануур дүүрэг			
25	I хороо, Хуцагийн 16-21 дүгээр гудамж	84	70.000
Налайх дүүрэг			
26	П хороо, Нарлаг хороолол	99	71.000
	Эрчим хүчинд холбогдоогүй өрхийг эрчим хүчинд холбох төслийн дүн	2622	2.307.893
Цахилгааны хүчдэлийн уналттай өрхийн хүчдэлийг сайжруулах төсөл Баянзүрх дүүрэг			
27	Y хороо, 69 дүгээр сургуулийн хойд талд	288	162.100
28	XI хороо, Баянзүрхийн товчооны замын хойд талд	92	103.257
29	ХХШ хороо, АТП-1795, 1705-ын дэд станцын хооронд	123	85.315
Хан-Уул дүүрэг			
30	IX хороо, АТП-008, Буянт-Ухаа хороолол	147	82.263
31	IX хороо, ХТП-973, Буянт-Ухаа хороолол	78	64.000
Сэнгинохайрхан дүүрэг			
32	X хороо, Зүүннارانгийн 13 дугаар гудамжны задгай	147	82.000
33	XI хороо, Зүүннارانгийн 10 дугаар гудамж, ХТП-841, ХТП-835-ын дэд станцын баруун талд	177	97.000
34	IX хороо, Горькийн гудамж	147	60.600
35	IY хороо, Ихнارانгийн 29 дүгээр гудамж, АТП-1667 дэд станцын дэргэд	147	80.603
36	ХХП хороо, Хилчний 93-107 дугаар гудамж, АТП-1667 дэд станцын дэргэд	150	85.638
37	ХХШ хороо, Хангайн 33 дугаар гудамж, АТП-1664 дэд станцын дэргэд	138	77.021
38	I хороо, Толгойт 110-129 дүгээр гудамж, Нарангийн гол АТП-1700 дэд станцын дэргэд	96	96.000
39	I хороо, Толгойтын 67 дугаар гудамж	84	65.629
40	Y хороо, Баянголын 1-6 дугаар гудамж, АТП-416 дэд станцын дэргэд	201	96.629
41	XIY хороо, 1 дүгээр хорооллын арын дэнжийн Алтайн 10-13 дугаар гудамж	86	114.000



42	YI хороо, АТП-034, Баянголын 46-56 дугаар гудамж	165	945.000
43	IY хороо, АТП-425, Ихнарангийн 1-8 дугаар гудамж	370	
44	IY хороо, АТП-445 /431/, Ихнарангийн 8-15 дугаар гудамж	255	
45	IX хороо, АТП-446, баруун Баянцагааны 10-12 дугаар гудамж	270	
46	IY хороо, АТП-702, Ихнарангийн 20-25 дугаар гудамж	270	
47	IX хороо, АТП-738, Уулын гудамж	275	
48	ХХУ хороо, АТП-1462, Зүүнсалаа 23-30 дугаар гудамж	165	
49	ХХУ хороо, Шинэ АТП-2008, Хайрханы гудамж	155	
50	YП хороо, Шинэ АТП-2010, Зээлийн гудамж	245	
51	YI хороо, Шинэ АТП-2013, Баянголын 35-65 дугаар гудамж	210	
52	YI хороо, Шинэ АТП-2014, Баянголын 31-60 дугаар гудамж	220	
53	Ш хороо, Шинэ АТП-2017, Баганарангийн 2-20 дугаар гудамж	275	
54	IY хороо, Шинэ АТП-2019, Ихнаран, Мал тууврын зам	85	
55	П хороо, АТП-021, Орбитын 33 дугаар гудамж	170	
56	П хороо, АТП-022, Орбитын 6 дугаар гудамж	275	
57	Y хороо, АТП-028, Баянголын 1-5 дугаар гудамж	135	
58	Y хороо, АТП-326, Сонгинохайрхан дүүргийн урд талд	40	
59	IX хороо, АТП-422, баруун Баянцагаан	310	
60	IY хороо, АТП-453, Их нарангийн 9-19 дүгээр гудамж	350	
61	ХХУ хороо, АТП-522, Зүүнсалаа 4-12 дугаар гудамж	315	
62	YП хороо, АТП-594, Зүүн Баянцагаан	210	
63	П хороо, АТП-840, Баганарангийн 13 дугаар гудамж	210	
64	Y хороо, АТП-898, Баянголын гудамж	295	
65	IX хороо, АТП-994, Зүүнсалаа 13-24 дүгээр гудамж	265	

66	ҮI хороо, АТП-999, Тоосгоны 3-7 дугаар гудамж	190	
67	XXIY хороо, АТП-1017, Зээлийн барилга	180	
68	ҮI хороо, КТП хүрээ, Тоосгоны гудамж	240	
69	ҮI хороо, ХТП-536, Тоосгоны 17-24 дүгээр гудамж	290	
70	П хороо, ХТП-703, Мал тууврын зам	160	
71	ҮI хороо, АТП-1426, Дэнжийн 35 дугаар гудамжны задгай	195	
72	IX хороо, АТП-864, Уулын 5-9 дүгээр гудамж, Зүүнсалааны 1-4 дүгээр гудамж	198	
73	ҮП хороо, АТП-929, зүүн Баянцагаан	60	
74	IX хороо, АТП-785, Малчны 2 дугаар гудамж	185	
75	ҮI хороо, АТП-1573, Тоосгоны 1-3 дугаар гудамж	95	
76	П хороо, АТП-528, Орбитын 25 дугаар гудамж	230	
77	ҮП хороо, АТП-418, Баянголын 27-56 дугаар гудамж	225	
78	Ү хороо, АТП-416, Баянголын гудамж	345	
79	Ү хороо, АТП-1029, Их нарангийн 32-34 дүгээр гудамж	255	
Сүхбаатар дүүрэг			
80	XIX хороо, АТП-554, Дээд салхитын 24-36 дугаар гудамж	144	70.552
81	XҮШ хороо, Дамбадаржаагийн 81-84 дүгээр гудамж, Архуст, Булагийн 16-22 дугаар гудамж, АТП-977-гийн ард	201	103.000
	Цахилгааны хүчдэлийн уналттай өрхийн хүчдэлийг сайжруулах төслийн дун	10829	2,470.607
	Нийт дүн	13451	4,778.500

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2009 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

**Цөмийн энергийн тухай хуулийн зарим заалт
Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай
маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 15.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, Үндсэн хуулийн цэцийн



гишүүн П.Очирбат /илтгэгч/, Н.Жанцан, Ж.Болдбаатар, Д.Мөнхгэрэл нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Н.Болортунгалагийг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд өргөдөл гаргагч, иргэн Б.Цэцэнбилэг, Б.Тэмүүлэн, Л.Лхаасүрэн, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Улсын Их Хурлын гишүүн Х.Бадамсүрэн нар оролцов.

Хуралдаанаар Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 болон 5.3 дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Тавдугаар зүйлийн 1, 2, 3, Аравдугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалт, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэв.

Нэг. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 16 дугаар хорооны оршин суугч, иргэн Б.Цэцэнбилэг 2009 оны 10 дугаар сарын 02-ны өдөр Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдөлдөө:

"...2009 оны 7 дугаар сарын 16-ны өдөр Улсын Их Хурлаас батлагдсан Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 болон 5.3 дахь хэсгийн заалтууд нь Үндсэн хуулийн дараах заалтуудыг зөрчиж байна. Үүнд:

Нэг. Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "...тэгш байдал, ...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн"

1.1. Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хуульчлагдсан төрийн үйл ажиллагааны тэгш байдлын зарчим нь Монгол Улсын төр, иргэн, хуулийн этгээд нь нийгмийн харилцаанд ямарваа ялгаваргүй, ижил тэгш нөхцлөөр хангагдаж, хууль, шүүхийн өмнө адил эрх эдэлж, үүрэг хүлээж оролцох үндсэн агуулгыг илэрхийлдэг.

Энэхүү агуулгаас үзэхэд "төрийн үйл ажиллагааны тэгш байдлын зарчим" гэдэг нь нийгмийн аливаа харилцаанд оролцож буй субъектүүдэд хууль, эрх зүйн тэгш нөхцлийг бий болгох шаардлагыг төрд бий болгодог бөгөөд Улсын Их Хурал нь аливаа хуулийг батлан гаргахдаа тухайн нийгмийн харилцаанд оролцогчдын тэгш байдлыг алдагдуулахгүй байх ёстой.

Гэтэл Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 болон 5.3 дахь хэсгийн заалтуудаар цацраг идэвхт стратегийн ач холбогдол бүхий

ашигт малтмалын ордын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны тодорхой хувь, хэмжээг төр "үнэ төлбөргүй, шууд" авахаар зохицуулсан нь аливаа ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд ялгавартай байдлыг бий болгож, тэгш байдлыг олгоогүй байна.

...Цөмийн энергийн тухай хуульд цацраг идэвхт стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьцааны тодорхой хувь, хэмжээг Монгол Улсын төр "ямар нэг хэмжээний хөрөнгө оруулахгүйгээр, үнэ төлбөргүй, шууд" авч, өөрийн өмчлөлд шилжүүлэх гэсэн агуулга бүхий зохицуулалт хийсэн нь нийгмийн харилцаанд оролцогчдын хувьд тэгш бус, ялгавартай нөхцөл байдлыг бий болгосон гэж үзэх үндэслэл болж байна...

1.2. Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хуульчлагдсан "хууль дээдлэх төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим" нь Монгол Улсын төр, иргэн, хуулийн этгээд нь өөрийн үйл ажиллагаандаа Үндсэн хууль болон бусад төрөлжсөн хуулиудыг хүндэтгэн сахин биелүүлэх, нийгмийн харилцаанд оролцогч талууд харилцан хариуцлага хүлээх, хүний болон иргэний эрх, эрх чөлөөг хангах, аливаа зөрчигдсөн эрхийг хамгаалах, сэргээх, төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа зөвхөн хуулийн хүрээнд явагдах, байгууллага, албан тушаалтан, иргэн хэн боловч хууль ёсыг чандлан сахих зэргээр хуулийн засаглал тогтоох агуулгыг илэрхийлдэг хэмээн онолын хувьд тодорхойлсон байдаг.

...Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 болон 5.3 дахь хэсэгт тусгагдсан заалтууд нь төр Үндсэн хуулиар тодорхойлогдоогүй аргаар бусдын өмчийг үнэ төлбөргүй авах зохицуулалтыг бий болгожээ.

...Иймээс Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 болон 5.3 дахь хэсгийн заалтууд нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "...тэгш байдал, ...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэж заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэл болж байна.

Хоёр. ...Цацраг идэвхт ашигт малтмалын ордын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн хувьцаа гэдгийг тусгайлан тодорхойлсон хууль Монгол Улсад байхгүй. Харин "компанийн хувьцаа" гэдгийг хуульд зааснаар тодорхойлвол "тухайн компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдан борлуулснаас олсон орлогоос хувь хүртэх болон хуулиар тогтоосон бусад эрхийг гэрчилсэн үнэт цаас" /Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь



заалтыг иш татсан/ бөгөөд "энэхүү үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг эдлэгч нь үнэт цаасны өмчлөгч байдаг" /Иргэний хуулийн 467 дугаар зүйлийн 467.8 дахь хэсгийн заалтыг иш татсан/.

Дээр дурдсанаас үзвэл компанийн хувьцааг "өмч" гэж тодорхойлсон ба энэ агуулгын хүрээнд "өмчлөгчийн эрх нь Үндсэн хуулиар хамгаалагдсан байна". Ийнхүү өмчлөх эрх хуулиар хамгаалагдсан хэдий ч өмчлөгчийн эрхийг Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар "...гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно" гэж зохицуулжээ. Гэвч энэ заалт нь өмчлөгчийн өмчлөлийн зүйлээ эзэмших, ашиглах, захиран зарцуулах, мөн хамгаалах эрхүүдийг /Иргэний хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх хэсгийн заалтыг иш татсан/ хязгаарлахад хамаардаг. Өөрөөр хэлбэл, өмчлөгч өөрийн эрхээ хуульд заасан хэмжээ, хязгаарын дотор эдлэх, хэрэв энэ үүргээ биелүүлэхгүй байгаа нь нийтийн ашиг сонирхолд харшилж байгаа бол хуульд зааснаар өмчлөгчийн эрхийг хязгаарлах агуулга юм...

...Хэрэв Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 болон 5.3 дахь хэсэгт тус тус тусгагдсан зохицуулалт нь бусдын өмчийг дайчлан авч буй хэлбэр гэж үзвэл Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3/-т "...Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө" гэж заасны дагуу зайлшгүй нөхөн төлбөр төлөх шаардлагатай юм.

...Иймээс Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 болон 5.3 дахь хэсгийн заалтууд нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална", Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3/-т "...Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө" гэж тус тус заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэл болж байна.

Гурав. ...Олон Улсын гэрээний тухай Монгол Улсын хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт зааснаар "Олон Улсын гэрээ гэж Монгол Улс, Монгол Улсын Их Хурал болон Монгол Улсын Засгийн газраас гадаадын нэг буюу хэд, хэдэн улс, тэдгээрийн Засгийн газар, олон улсын байгууллагатай тодорхой асуудлаар харилцан эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлон тогтоосон олон улсын эрх зүйгээр зохицуулагдах хоёр буюу олон талын бичгээр үйлдсэн тохиролцоог хэлнэ" гэжээ.

2009 оны байдлаар Монгол Улс нь гадаадын 40 гаруй улстай хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай гэрээ, хэлэлцээрийг байгуулсан бөгөөд Олон Улсын гэрээний тухай Монгол Улсын хуульд зааснаар тэдгээр 40 гаруй гэрээ, хэлэлцээрүүд нь Монгол Улсын олон улсын гэрээ мөн.

...“Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Бүгд Найрамдах Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн 2 болон 5 дугаар зүйлүүд, “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн 3 дугаар зүйлийн 1 болон 4 дүгээр зүйлүүд, “Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Бүгд Найрамдах Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн 5 дугаар зүйл, “Хөрөнгө оруулалтыг дэмжиж хамгаалах тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Энэтхэг улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн 5 дугаар зүйл болон Монгол Улсын бусад улсуудтай байгуулсан хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай хоёр талын гэрээнүүдэд хөрөнгө оруулалтыг хамгаалах, тэрхүү хөрөнгө оруулалт буюу бусдын өмчийг дайчлан авах тохиолдолд эрх зүйн урьдчилсан тодорхой нөхцөл үүссэн байх, хэрэв тухайн нөхцөл үүссэн тохиолдолд төрөөс нөхөн олговор зайлшгүй олгох тухай тусгагдаж, баталгаажсан байдаг байна.

Дээрх гэрээнүүд Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 3 дахь хэсэг, мөн Арван зургадугаар зүйлийн 3-т тус тус заасантай бүрэн нийцэж байгаа бөгөөд ийнхүү “бусдын өмчийг хамгаалах, мөн аливаа хэлбэрээр дайчлан авсан тохиолдолд нөхөн олговор олгох тухай” зохицуулалтууд байсаар атал Цөмийн энергийн тухай хуулийн Тавдугаар зүйлийн 5.2 болон 5.3 дахь хэсэгт бусдын өмчийг төр “үнэ төлбөргүйгээр, шууд” авах зохицуулалт бий болгосон нь Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улс нь олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэснийг зөрчсөн гэж үзэх үндэслэл болж байна.

Иймд ...Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дахь хэсгийн заалтууд нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “...тэгш байдал, ...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалт “... Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр,

түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө". Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн болохыг тогтоож, дүгнэлт гаргаж өгөхийг хүсье." гэжээ.

Хоёр. Нийслэлийн Хан-Уул дүүргийн 1 дүгээр хорооны оршин суугч, иргэн Б.Тэмүүлэн 2009 оны 10 дугаар сарын 05-ны өдөр Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдөлдөө:

"...Нэг. ...Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дахь хэсгийн заалтуудын зохицуулалтыг Ашигт малтмалын тухай хуулийн холбогдох зохицуулалттай харьцуулбал, Ашигт малтмалын тухай хуулийн Тавдугаар зүйлийн 5.4, 5.5 дахь хэсгүүдэд зааснаар "Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг хувийн өмчит хуулийн этгээдтэй хамтран ашиглавал төрийн оролцооны хэмжээ 50 хүртэл хувьтай байж болох бөгөөд уг хэмжээг төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлно", "Улсын төсвийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг эзэмшигчийн тухайн ордод оруулсан хөрөнгийн 34 хүртэлх хувьтай тэнцэх хувьцааг төр эзэмшиж болох бөгөөд уг хэмжээг төрөөс оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээг харгалзан орд ашиглах гэрээгээр тодорхойлно" гэжээ. Үүнээс үзвэл, газрын хэвлийд байдаг ашигт малтмал /алт, хүдэр, нүүрс гэх мэт/ болон цацраг идэвхт ашигт малтмалын хувьд, хоёулангийнх нь орд стратегийн ач холбогдолтой гэсэн ангилалд багтахын зэрэгцээ төсвийн хөрөнгөөр эрэл хайгуул хийх тохиолдолд төрийн оролцооны хувь хэмжээ нь төсвийн хөрөнгөөр эрэл хайгуул хийгээгүй нөхцлөөс их хэмжээтэй байх зэрэг адил нөхцөл байдал үүссэн буюу урьдчилсан нөхцлүүд нь нэгэн адил байхад ашигт малтмалын хувьд цацрагт идэвхт ашигт малтмалын зохицуулалтаас өөр байдлаар "тодорхой хэмжээний хөрөнгө оруулж, оруулсан хөрөнгийн хэмжээгээр хувь эзэмшихээр" зохицуулалт хийгдсэн байна. Энэ нь ...харилцаанд оролцогчдын ашиг сонирхлын байдал адил байхад, ашигт малтмалын болон цацрагт идэвхт ашигт малтмалын харилцааг ялгаатай байдлаар зохицуулсан нь тодорхой байна. Улмаар ашиг сонирхлын адил нөхцөлд байгаа этгээдүүдэд төрийн зүгээс адил боломж олгож, адил эрх зүйн зохицуулалт хийгээгүй нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт тусгасан "шударга ёсны" зарчмыг зөрчиж байна гэж үзэх үндэслэл болно.

Хоёр. ...Цөмийн энергийн тухай хуульд хувьцааны тухай ойлголт, гүйцэтгэх чиг үүрэг зэрэг ойлголтуудыг тодорхойлох шаардлагагүй тул энэ

ойлголтыг зохицуулсан холбогдох хуулиудад шууд хандвал, Компанийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасны дагуу "Хувь нийлүүлэгчдийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгаарласан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээдийг компани гэнэ", түүнчлэн тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт зааснаар "Хувьцаа нь тухайн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох бөгөөд компанийн аливаа нэг эд хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй". Харин Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-т заасны дагуу "Хувьцаа гэдэг нь компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдан борлуулснаас олсон орлогоос хувь хүртэх болон хуулиар тогтоосон бусад эрхийг гэрчилсэн үнэт цаас" гэж хувьцааны тухай ойлголтыг тодорхойлсон байна...

Харин Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дахь хэсгийн заалтуудад хуульчилсан "үнэ төлбөргүйгээр" хамтарсан компанийн хувийг эзэмших зохицуулалт нь дээр дурдсан холбогдох хуулиудын хувьцааны тухай заалт, зохицуулалтыг зөрчиж буй нь илэрхий байна...

Цөмийн энергийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1-т заасны дагуу "энэ хуулийн 5.2 буюу 5.3-т заасан нөхцөлийг зөвшөөрснөө нотолсон албан ёсны шийдвэр"-ийг тусгай зөвшөөрөл хүсэгч нь бүрдүүлэн өгөх бичиг баримтанд хавсаргах үүрэг хүлээж байгаа. Цөмийн энергийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 1, 2, 3 дугаар зүйлүүдэд зааснаар "Цөмийн энергийн тухай хууль хүчин төгөлдөр болохоос өмнө олгосон цацрагт идэвхт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2009 оны 11 дүгээр сарын 15-ны дотор уг хуульд заасан нөхцөл журмын дагуу шинэчлэн бүртгэх" бөгөөд шинэчлэн бүртгүүлэх тухай өргөдөлдөө "тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Цөмийн энергийн тухай хуульд заасан төрийн оролцооны хувийг төрд эзэмшүүлэхийг зөвшөөрснөө нотолсон албан ёсны шийдвэрийг ...хавсаргасан байна". Нэгэнт үүсгэн байгуулагдчихсан, үйл ажиллагаагаа эрхлэн явуулж буй компанийн хувь нийлүүлэгчдийн хувьцаанаас холбогдох хуульд заасан тодорхой хувийг үнэ төлбөргүйгээр төрийн эзэмшилд шилжүүлж буй тохиолдолд энэ нь компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд хамаарах хэсгийг эрх бүхий субъектын хүсэл зоригоос хамааралгүйгээр төрийн өмчлөлд шилжүүлж буй явдал бөгөөд үүний хариуд үнэ төлбөр төлөхгүй байх нь Үндсэн хуульд тунхаглагдсан хууль дээдлэх, хууль ёсны байх зарчмыг зөрчиж байгаа билээ.



Үнэт цаас болж байгаагийн хувьд Иргэний хуулийн 467 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу "Үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг эдлэгч нь үнэт цаасны өмчлөгч байна". Улмаар хувьцаа үнэт цаас болж байгаа учир хувьцаа эзэмшигч нь түүний өмчлөгч байх ба үнэт цаасны хувьд өмчлөх эрх эдлэх юм. Өмчлөх эрхийн тухай ойлголтыг хувийн эрх зүйд тодорхойлсон байдаг бөгөөд өмчлөх эрх субъектив эрх болж байдаг. ...Улмаар Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дахь хэсгийн заалтууд нь субъектив эрх болж буй үнэт цаасыг өмчлөх эрх шилжих хувийн эрх зүйн догматикийг зөрчиж байгаа нь тодорхой байна...

Гурав. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад "Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө" гэжээ. Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дахь хэсгийн заалтуудын дагуу цацрагт идэвхт ашигт малтмалын ордыг хамтарсан компани байгуулж, хувь нийлүүлэгч болж буй хуулийн этгээдийн хүсэл зоригоос гадуур, үл хамааран хувьцааны тодорхой хувийг төрийн мэдэлд шилжүүлнэ гэдэг нь Үндсэн хуульд тусгагдсан дайчлан авах үйлдэл мөн гэж үзэж болох юм. ...Гэхдээ Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтад заасны дагуу дайчлан авч буй тохиолдолд заавал нөхөн олговор эсхүл төлбөр төлөх шаардлагатай...

Дөрөв. ...Цацрагт идэвхт ашигт малтмалыг ашиглах зорилгоор үүсгэн байгуулах хамтарсан компанийн хувьд хувь нийлүүлэгчдийн хувиа оруулан өмчилж буй хувьцааг төр үнэ төлбөргүй авна гэдэг нь бусдын өмчлөлийн зүйлийг, тодруулбал, бусдын хөдөлмөр, зүтгэл, мөнгө, хөрөнгөөр олж авсан үнэт цаас болох хувьцааг хариу төлбөргүйгээр олж авч байгаа үйлдэл билээ. Энэ нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг болон Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтыг давхар зөрчиж байна гэж үзэх үндэслэл байгааг нотолж байна. Учир нь өмчийн баталгаа гэх ойлголтод аливаа зүйлсийг өөрөө хариуцлага хүлээх нөхцөлтэйгээр өөрийн үйлдэл, хөрөнгө, ажил хөдөлмөрөөр олж авна гэсэн үзэл санаа багтах бөгөөд өөрийн хөдөлмөр, ажил, хөрөнгө, мөнгө, хичээл зүтгэлээр олж авсан зүйлсийг өөр этгээд авч байгаа бол заавал хариу нөхөн төлбөр өгөх шаардлага урган гарч ирж байна.

Тав. ...Монгол Улс бусад улстай байгуулсан хөрөнгө оруулалтыг дэмжих тухай хоёр талын 40 гаруй олон улсын гэрээ байдгаас жишээ болгон дурдвал, Монгол Улс Америкийн Нэгдсэн Улстай байгуулсан "Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улсын хоорондын гэрээ" бөгөөд тус гэрээний ...3

дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар "Нийтийн ашиг сонирхлын үүднээс ялгаварлан гадуурхахгүйгээр, хойшлуулахгүй зохих ёсны, үр ашигтай нөхөн төлбөр хийх үндсэн дээр зохих хууль болон хоёрдугаар зүйлийн 2-т заасан нөхцлийн ерөнхий зарчмын дагуу гүйцэтгэхээс бусад тохиолдолд хөрөнгө оруулалтыг хураан авах, нийгэмчлэх /дайчлан гаргуулах/ буюу үүнтэй адилтгах аливаа арга замаар шууд буюу шууд бусаар хураан авах буюу нийгэмчилж болохгүй" байна.

...Иймд Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дахь хэсгийн заалтууд нь мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалт болох "Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн байх" цацрагт идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн үйл ажиллагаанд баримтлах зарчмыг, түүнчлэн Монгол Улсын олон улсын гэрээг, улмаар Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалтуудыг зөрчиж байна. Цөмийн энергийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1 дэх заалтын дагуу "энэ хуулийн 5.2 буюу 5.3-т заасан нөхцөлийг зөвшөөрснөө нотолсон албан ёсны шийдвэр"-ийг тусгай зөвшөөрөл хүсэгч нь бүрдүүлэн өгөх бичиг баримтанд хавсаргах үүрэг хүлээж байгаа. ...Ийнхүү шийдвэрийг хавсаргаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлөө хураалгах, алдах нөхцөл байдал үүснэ. Гэтэл энэ нь Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалтуудыг зөрчиж буй явдал билээ.

Иймд Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дахь хэсгийн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалт, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтыг зөрчиж байгааг хянан шийдвэрлэж өгнө үү" гэжээ.

Гурав. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны оршин суугч, иргэн Л.Лхаасүрэн 2009 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдөлдөө:

"Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн "Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон цацраг идэвхт ашигт малтмалын ордыг бусадтай хамтран ашиглах тохиолдолд түүнтэй хамтран байгуулах компанийн хувьцааны 51-ээс доошгүй хувийг төр үнэ төлбөргүй, шууд эзэмшинэ" гэсэн заалт, мөн зүйлийн 5.3 дахь хэсгийн "Улсын төсвийн хөрөнгийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоон улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн орд газарт цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн хувьцааны 34-өөс доошгүй хувийг төр үнэ төлбөргүй, шууд эзэмшинэ" гэсэн заалтууд нь хуулийн хувьд ихээхэн учир дутагдалтай байгаад зогсохгүй Үндсэн хуулийг ноцтой зөрчсөн байна.



Энэ заалтуудад дурдсан хувьцаа гэдэг үгсийг анхаарч үзвэл энэ нь Иргэний хуулийн тодорхойлолтын дагуу өмч гэж тодорхойлогдсон байна. Компанийн хувьцаа яригдаж байгаа бол гарцаа байхгүй тухайн компанийн хувь эзэмшигчийн өмч, аж ахуйн баланс бүртгэл дээр нь тодорхой үнэ цэнэ агуулж байдаг үнэт цаас юм.

...Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийн заалтууд тус тус ноцтойгоор зөрчигдлөө. Дээр дурдсаны дагуу хувьцаа бол өмч мөн. Үндсэн хууль бол хөдөлмөрчдийн өмчийг хамгаалах хамгийн том баталгаа байх ёстойн дагуу "шууд" бөгөөд "үнэ төлбөргүй" өмчөөс салгах үндэс байхгүй.

...Иймд...дээрх хоёр хуулийн дурдсан заалт буюу Цөмийн Энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 болон 5.3 дахь хэсгийн заалт, Цөмийн Энергийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйл тус тус Үндсэн хуультай зөрчилдөж байгааг тогтоож, улмаар хүчингүйд тооцож өгнө үү" гэжээ.

Дөрөв. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Х.Бадамсүрэн Үндсэн хуулийн цэцэд 2009 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр гаргасан тайлбартаа:

"...Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дахь хэсгийн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Аравдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтыг... зөрчөөгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна", мөн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн", түүнчлэн Иргэний хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт "Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар төрийн өмчид байна" гэж Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүний хэвлийд байгаа баялгийн өмчлөл төрд хадгалагдахаар тодорхойлсон.

...Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ: 1/ хууль батлах,..." гэж



заасан онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд Цөмийн энергийн тухай хуулийг 2009 оны хаврын ээлжит чуулганаараа хэлэлцэж батлахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт заасан бүрэн эрх, мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэгт заасны дагуу холбогдох нөхцөл, журмыг хуулиар тодорхойлж хуулийн этгээдэд төрийн нийтийн зориулалттай өмчлөлийн зүйл буюу энэ тохиолдолд газрын хэвлий, түүний баялгийг эзэмшүүлэх, ашиглуулахдаа төр өөрийн эзэмших хувь хэмжээгээ тогтоосон. Уг хувь хэмжээ нь газрын хэвлий, ой, ус, ан амьтан зэрэг баялгийг төр өмчлөх эрхийг хөндөөгүй, харин тухайн баялгийн зарим хэсгийг зохих журмын дагуу ашиглах эрх бүхий хамтарсан өмчит хуулийн этгээдийн хувьцааны тодорхой хэсгийг өмчлөх эрхийг төрд олгосон юм.

...Өнөөдрийн байдлаар Монгол Улс нь цөмийн аюулгүйн чиглэлээр болон Олон улсын атомын энергийн агентлагийн хүрээнд дараахь олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенц, протоколд нэгдэн орж соёрхон баталсан билээ.

...Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ" гэж заасны дагуу олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж, шаардлагатай арга хэмжээг цаг тухай бүрт нь үе шаттайгаар хэрэгжүүлж, холбогдох хууль тогтоомжийг Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэн ажиллаж байгаа билээ.

...Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогын 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх хэсэгт "цацраг идэвхт ашигт малтмал нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, эдийн засагт онцгой ач холбогдолтойг харгалзан цацраг идэвхт ашигт малтмалын ордыг хэмжээнээс нь үл хамааран стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулна" гэж тодорхойлсон...

Үүнээс дүгнэхэд төр өөрийн өмчийг, тодруулбал газар, газрын хэвлий, түүний баялаг буюу энэ тохиолдолд цацраг идэвхт ашигт малтмал - стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмал, ордыг хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийн дагуу шаардлагатай нөхцөл, журмын дагуу буюу дотоод, гадаадын төрийн өмчийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд ашиглуулахдаа хамтарсан компани байгуулж, түүний хяналтын багцыг эзэмшинэ. Төр өөрийн өмчийг ашиглуулахдаа буюу бусад хуулийн этгээдтэй хамтран нөөцийг ашиглахдаа улсын төсвийн хөрөнгийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоон улсын нэгдсэн бүртгэлд



бүртгэсэн орд газарт цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн хувьцааны 34-өөс доошгүй хувь, улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон цацраг идэвхт ашигт малтмалын ордыг бусадтай хамтран ашиглах тохиолдолд түүнтэй хамтран байгуулах компанийн хувьцааны 51-ээс доошгүй хувийг төр бэлэн бусаар буюу өөрийн өмч буюу газар, газрын хэвлий, түүний баялгаар хөрөнгө оруулж байгаа гэсэн ойлголт юм. Түүнчлэн, дээр дурдсанчлан цацраг идэвхт ашигт малтмал нь стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмал учраас төр цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий хамтарсан компанийн хяналтын багцыг зайлшгүй өөртөө хадгалах шаардлага нь зүй ёсны бөгөөд энэ нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдалтай шууд холбоотой юм” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...газрын хэвлий, түүний баялаг төрийн өмч мөн” гэж заасан байна.

Цөмийн энергийн тухай Монгол Улсын хуульд улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн болон улсын төсвийн хөрөнгийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг тогтоосон цацраг идэвхт ашигт малтмалын ордыг хамтран эзэмшигч компанийн хувьцаанаас төр өөрийн эзэмших хувь хэмжээ, нөхцөлийг тогтоосон нь Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарч байна.

Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт “Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон цацраг идэвхт ашигт малтмалын ордыг бусадтай хамтран ашиглах тохиолдолд түүнтэй хамтран байгуулах компанийн хувьцааны 51-ээс доошгүй хувийг төр үнэ төлбөргүй, шууд эзэмшинэ”, мөн зүйлийн 5.3 дахь хэсэгт “Улсын төсвийн хөрөнгийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоон улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн орд газарт цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн хувьцааны 34-өөс доошгүй хувийг төр үнэ төлбөргүй, шууд эзэмшинэ” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “...шударга ёс, ...тэгш байдал, ...хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна”, Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”, Тавдугаар зүйлийн 3 дахь хэсгийн

"Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно", Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ", Аравдугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ", Арван зургадугаар зүйлийн 3/-ын "Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон Монгол Улсын Үндсэн хуулийн нэрийн өмнөөс **ДҮГНЭЛТ гаргах нь:**

1. Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн "Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг нь тогтоосон цацраг идэвхт ашигт малтмалын ордыг бусадтай хамтран ашиглах тохиолдолд түүнтэй хамтран байгуулах компанийн хувьцааны 51-ээс доошгүй хувийг төр үнэ төлбөргүй, шууд эзэмшинэ", мөн зүйлийн 5.3 дахь хэсгийн "Улсын төсвийн хөрөнгийн оролцоогүйгээр хайгуул хийж нөөцийг нь тогтоон улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн орд газарт цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн хувьцааны 34-өөс доошгүй хувийг төр үнэ төлбөргүй, шууд эзэмшинэ" гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Тавдугаар зүйлийн 1, 2, 3, Аравдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3/ дахь заалтыг тус тус зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг хүлээн авч, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

ГИШҮҮД

Ж.БЯМБАДОРЖ

П.ОЧИРБАТ

Н.ЖАНЦАН

Ж.БОЛДБААТАР

Д.МӨНХГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ2009 оны 10 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 31

Улаанбаатар
хот**ХОХИРОГЧИД НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ ТУХАЙ
ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ШҮҮХИЙН
ПРАКТИКТ ХЭРЭГЛЭХ ТУХАЙ**

Хохирогчид нөхөх олговор олгох тухай хуулийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн Хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5.-д заасныг удирдлага болгон **Улсын Дээд шүүхээс ТОГТООХ НЬ:**

1.Хохирогчид нөхөх олговор олгох тухай хуулийн (цаашид хуулийн гэх) 4 дүгээр зүйлийн 4.1.4., 4.2.-т заасан хохирлын хэмжээ нь **"шүүхийн шийдвэрээр тогтоогдсон"** байна гэдэг нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 301, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 120 дугаар зүйлд тус тус зааснаар хүчин төгөлдөр болсон эрүү, иргэний хэргийн тогтоол, шийдвэрт заагдсан байхыг хэлнэ.

2.Хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу хохирогчид улсын төсвөөс нөхөх олговор олгох нь Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1.-д зааснаар гэм буруутай этгээдэд хариуцлага тооцож байгаа явдал биш учир хохирол учруулсан этгээдийг гэм хорыг арилгах хуульд заасан үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

Эд хөрөнгийн болон эдийн бус хохирлын хэмжээг шүүхээр тогтоолгосноор улсын төсвөөс нөхөх олговор авах эрх үүсэх учир хохирлын хэмжээ тогтоолгох тухай хохирогчийн шаардлагыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3.-т заасан иргэний хэрэг үүсгэх үндэслэлтэй адилтгаж болно.

Хохирлын хэмжээ тогтоосон шүүхийн шийдвэрт улсын төсвөөс нөхөх олговор гаргуулах асуудлыг нэг мөр шийдвэрлэнэ.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ**С.БАТДЭЛГЭР****ТАНХИМЫН ТЭРГҮҮН****Ц.АМАРСАЙХАН**


Ханг:

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакци,
Улаанбаатар-12, Төрийн ордон 128 тоот
И-мэйл: turin_medeel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуулас 3

Индекс: 14003



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсэгт хэвлэв.
Утас 329487